

28 ЧУУЛГАНУУД

28.1 ДОЛООН ЧУУЛГАНД ИЛГЭЭСЭН ЗАХИДАЛ

1Удахгүй болох ёстой юмсыг Өөрийн боолууддаа үзүүлэхийн тулд Бурханы Түүнд өгсөн Есүс Христийн илчлэлт. Тэр тэнгэр элчээ илгээж Өөрийн боол Иоханд үүнийг мэдүүлжээ.²Иохан нь Бурханы үг болон Есүс Христийн гэрчлэлийг төдийгүй өөрийн үзсэн бүхнээ гэрчилсэн болой.³Энэхүү эш үзүүллэгийн үгсийг уншигч болон сонсоод, үүнд бичигдсэн зүйлсийг сахигчид нь ерөөлтэй ээ! Учир нь цаг ойрхон байна.

⁴Иоханаас Ази дахь долоон чуулганд илгээв. Байгаа болон байсан, мөн хожим ирэх Түүнээс болон Түүний сэнтийн өмнө байх долоон сүнснээс,⁵мөн итгэмжит гэрч ба үхэгсдээс анх төрсөн бөгөөд газрын хаадын захирагч Есүс Христээс нигүүлсэл ба амар тайван нь та нарт байх болтугай. Биднийг хайрладаг бөгөөд Өөрийнхөө цусаар биднийг нүглээс минь чөлөөлж,⁶биднийг хаанчлал болоод Бурхан ба Өөрийн Эцэгийн төлөөх тахилч нар болгосон Түүнд үеэс үед алдар хийгээд ноёрхол нь байх болтугай. Амен.
(Илчлэлт 1:1-6 АБ 2004)

³Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дотор тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн.⁴Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор сонгосончлон, хайраараа⁵Тэр Өөрийн хүслийн сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр Өөрийнхөө хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоожээ.⁶Энэ нь хайрлагдсан Түүний дотор бидэнд соёрхсон Түүний нигүүлслийн алдрыг магтуулахын тулд болой. (Эфес 1:3-6 АБ 2004)

[] Түүний дахин ирэх цаг ойртож байгааг та мэдэх үү?

28.2 Хайргүй Ефес

1Ефес дэх чуулганы тэнгэр элчид бичигтүн.

“Баруун мутартаа долоон одыг баригч Нэгэн, долоон алтан дэнлүүний суурийн дунд алхагч Нэгэн үүнийг айлдаж байна. ²“Би чиний ажил үйлс, нөр хөдөлмөр, тэвчээрийг чинь болон муу хүмүүсийг тэсвэрлэж чадаагүйг болон өөрсдийгөө элч нар хэмээдэг атлаа, чухамдаа элч биш хүмүүсийг шалгаж, хуурамч хүмүүс байсныг нь илчилснийг чинь мэднэ. ³Чи тэвчээртэй байж, Миний нэрийн төлөө хүлцэн тэвчиж, цуцаагүй. ⁴Харин Надад чиний эсрэг зүйл байна. Юу гэвэл чи анхны хайраа орхижээ. ⁵Тиймээс чи хаанаас унаснаа санаж гэмш. Чи анх хийж байсан үйлсээ үйлд. Хэрэв чи гэмшихгүй бол, Би чам уруу очиж, дэнлүүний чинь суурийг байрнаас нь зайлуулах болно. ⁶Гэвч чамд сайн юм бий. Юу гэвэл Миний үзэн яддаг николайчуудын үйлсийг чи ч мөн үзэн яддаг. ⁷Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун. Бурханы диваажинд буй амийн модноос идэхийг Би ялагч нэгэнд соёрхоно” (Илчлэлт -2:1-7 АБ 2004)

- [] Амийн модноос идэхийн тулд юуг даван туулахыг та мэдэх үү?
 [] Түүний ажлыг (анхны хайраас унасан-дуулгавартай байх)
 өөрийн замаар хийхэд юу хүргэдэг вэ?

28.3 Смирна, хавчигдсан

⁸Смирна дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Үхсэн бөгөөд амилсан эхэн ба эцэс үүнийг айлдаж байна. ⁹“Би чиний зовлон шаналал, ядуу байдлыг (гэвч чи баян) болон өөрсдийгөө иудейчүүд хэмээгчдээр доромжлогддогийг чинь мэднэ. Харин тэд иудейчүүд биш бөгөөд Сатаны синагог юм. ¹⁰Эдлэх гэж буй зовлонгоосоо бүү ай. Үзэгтүн, диавол та нарыг сорихын тулд та нараас заримыг чинь шоронд хаях гэж байна. Та нарт арван өдөр гай зовлон учрах болно. Үхэл хүртэл итгэмжтэй бай. Тэгээд Би чамд амийн титмийг өгнө. ¹¹Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун. Ялагч нь хоёр дахь үхлээр хохирохгүй” (Илчлэлт 2:8-11 АБ 2004)

- [] Амийн титмийг хэрхэн олж авах ба хоёр дахь үхлээр хохирохгүй байхыг та мэдэх үү?

28.4 Пергам, буулт хийх

¹²Пергам дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Хоёр талдаа хурц ирт илдтэй Нэгэн үүнийг айлдаж байна.”¹³“Би чиний хаана нутагладгийг болон тэнд чинь Сатаны сэнтий байдгийг мэднэ. Чи Миний нэрийг бат сахидаг бөгөөд Миний итгэлийг үгүйсгээгүй, бүр Сатаны нутагладаг газарт, та нарын дунд алагдсан Миний гэрч, Миний итгэлт нэгэн болох Антипын өдрүүдийн үед ч үгүйсгээгүй билээ.”¹⁴Харин чиний эсрэг хэдэн зүйл Надад байна. Яагаад гэвэл чиний тэнд Балаамын сургаалыг сахигчид байдаг. Балаам нь Израилийн хөвгүүдийн өмнө бүдрүүлэх саад тавиулах гэж, шүтээнүүдэд тахисан юмсыг идүүлж, садар самууныг үйлдүүлэх гэж Балакийг сургасаар байсан.¹⁵Тэрчлэн үүний адилаар николайчуудын сургаалыг сахигчид ч чамд бий.¹⁶Тиймээс гэмшигтүн. Эс бөгөөс Би чам уруу даруй очиж, амныхаа илдээр тэдэнтэй тулалдах болно.¹⁷Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун. Ялагчид Би нууцалсан маннагаас өгнө. Би түүнд цагаан чулуу болон түүнийг хүлээн авагчаас өөр хэн ч мэдэхгүй чулуун дээр бичигдсэн шинэ нэр өгнө”.

(Илчлэлт 2:12-17 АБ 2004)

[] Та Бурханы үгийг цэвэр байлгаж ба хүний сургаалтай холихгүй байлгадаг уу ?

28.5 Туатейр, ялзарсан

¹⁸Туатейр дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Галын дөл мэт нүдтэй, өнгөлсөн хүрэл мэт хөлтэй, Бурханы Хүү үүнийг айлдаж байна.”¹⁹“Би чиний ажил үйлс, хайр, итгэл, үйлчлэл, тэвчээрийг болон эцсийн ажил үйл чинь эхнийхээсээ агуу гэдгийг мэднэ.”²⁰Гэвч чиний эсрэг зүйл Надад байна. Юу гэвэл өөрийгөө эш үзүүлэгч хэмээн нэрлэдэг Иезебел гэгч эмэгтэйд Миний боолуудыг сурган, төөрөлдүүлэхийг чи зөвшөөрсөн. Тэгснээр тэд садар самуун үйлдэн, шүтээнүүдэд өргөсөн юмсыг иддэг ажээ.²¹Би тэр эмэгтэйд гэмших хугацаа өгсөн. Харин тэр садар самуун үйлдсэндээ гэмшихийг хүсдэггүй.²²Харагтун, Би түүнийг орон дээр хаяна. Хэрэв тэд тэр эмэгтэйн үйлдэлд гэмшихгүй бол, түүнтэй завхайрагчдыг үлэмж гай зовлонд унагана.²³Түүний хүүхдүүдийг Би үхлээр

хөнөөнө. Би бол оюун санааг хийгээд зүрхийг Нягтлагч гэдгийг бүх чуулган мэдэх болно. Би та нарын хүн нэг бүрд үйлсийнх нь дагуу хариу өгнө.²⁴Харин Туатейрт үлдсэн, энэ сургаалыг сахидаггүй, өөрсдийнх нь нэрлэдгээр Сатаны гүн юмсыг мэддэггүй та нарт Би хэлье. Би та нарын дээр өөр дарамт тавихгүй.²⁵Гагцхүү юу байгаагаа Намайг очтол бат сахь.²⁶Ялагч ба Миний үйл хэргийг эцэс хүртэл хамгаалдаг хүнд Би үндэстнүүдийг захирах эрх мэдлийг өгнө.²⁷Би Эцэгээсээ эрх мэдлийг хүлээн авсан. Үүнчлэн тэр хүн шавар сав суулгануудыг хага цохих адил тэднийг төмөр таягаар захирах болно.²⁸Би түүнд үүрийн цолмонг өгнө.²⁹Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун”. (Илчлэлт 2:18-29 АБ 2004)

[] Та өөрийгөө бузар муу, садар самуун явдлаас холуур байлгаж байгаа юу ?

[] Та цэвэр ариун байдлыг хадгалахын үр шимийг мэдэх үү ?

28.6 Сардей, үхсэн сүм

1Сардей дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Бурханы долоон Сүнс ба долоон одтой Тэр үүнийг айлдаж байна. “Би чиний үйлсийг, чиний амьд гэдэг нэртэй боловч үхдэл гэдгийг чинь мэднэ.²Сэрэгтүн, үхэх гэж байсан үлдсэн юмсаа тэнхрүүл. Учир нь Миний Бурханы өмнө чиний үйлс гүйцэлдснийг Би олсонгүй.³Тиймээс чи юу хүлээн авсан болон сонссоноо сана. Түүнийг сахь, гэмш. Хэрэв чи сэрэхгүй бол Би хулгайч мэт очно. Ямар цагт Миний чам дээр очихыг чи мэдэхгүй.⁴Гэвч хувцсаа хиртүүлээгүй цөөн хүн Сардейд чамд бий. Тэд Надтай хамт цагаан хувцастай алхах болно. Яагаад гэвэл тэд зохистой хүмүүс мөн.⁵Энэ мэт ялагч нь цагаан хувцас өмсөнө. Би түүний нэрийг амийн номоос баллахгүй. Би Өөрийнхөө Эцэгийн өмнө болоод Түүний тэнгэр элч нарын өмнө түүний нэрийг хүлээн зөвшөөрнө.⁶Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун”. (Илчлэлт 3:1-6 АБ 2004)

[] Эзэн дотор таны ажил хэрхэн төгс гэгдэхийг та мэдэх үү?

28.7 Филадельфи, үнэнч

⁷Филадельфи дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Нээхэд нь хэн ч хаахгүй, хаахад нь хэн ч нээхгүй, Давидын түлхүүртэй, үнэн бөгөөд ариун Нэгэн үүнийг айлдаж байна. ⁸“Би чиний үйлсийг мэднэ. Харагтун, хэн ч хааж үл чадах нээлттэй хаалгыг Би чиний өмнө тавьсан. Юу гэвэл чиний хүч бага бөгөөд чи Миний үгийг сахиж, Миний нэрийг үгүйсгээгүй билээ. ⁹Үзэгтүн, Иудей биш атлаа өөрсдийгөө Иудей хэмээн худал яригч Сатаны синагогийн хүмүүсийг Би ирүүлж, хөлийн чинь өмнө бөхийлгөж, Би чамайг хайрласан гэдгээ мэдүүлнэ. ¹⁰Миний тэвчээрийн үгийг чи сахисан учраас Би бас чамайг сорилтын цагаас буюу газар дээр нутаглагсдыг сорихын тулд бүх дэлхий дээр ирэх гэж буй тэр цагаас хамгаалах болно. ¹¹Би удахгүй очно. Хэнд ч титмээ алдахгүйн тулд өөрт байгаагаа бат сахь. ¹²Би ялагчийг Өөрийн Бурханы сүм дэх багана болгоно. Тэр цаашид тэндээс гарахгүй. Би түүн дээр Өөрийн Бурханы нэр, тэнгэрээс Миний Бурханаас буун ирэх шинэ Иерусалим буюу Өөрийн Бурханы хотын нэр, Өөрийн шинэ нэрээ бичнэ. ¹³Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун”. (Илчлэлт 3:7-13 АБ 2004)

[] Та нэрээ Шинэ Иерусалимд бичүүлэхийг хүсч байна уу?

28.8 Лаодик, бүлээн

¹⁴Лаодик дахь чуулганы тэнгэр элчид бичигтүн. “Амен, итгэмжит бөгөөд үнэн Гэрч болох Бурханы бүтээлийн Анхдагч нь үүнийг айлдаж байна. ¹⁵“Би чиний үйлсийг, хүйтэн ч биш, халуун ч биш гэдгийг чинь мэднэ. Чамайг хүйтэн юм уу, эсвэл халуун байгаасай гэж Би хүсэж байна. ¹⁶Тийнхүү чи халуун ч биш, хүйтэн ч биш, бүлээвтэр тул Би чамайг амнаасаа бөөлжиж гаргана. ¹⁷Яагаад гэвэл чи “Би баян. Баяжсан тул дутах зүйл ер байхгүй” гэдэг. Чи өөрийнхөө хөөрхийлөлтэй, өрөвдмөөр, ядуу, сохор, нүцгэн байгааг мэдэхгүй байна. ¹⁸Баян болохын тулд галд цэвэршүүлсэн алт, өөрийгөө хувцаслахын тулд болон нүцгэн байдлын чинь ичгүүр ил болчихгүйн тулд цагаан хувцас,

харахын тулд нүдээ тослох нүдний тосыг Надаас худалдан ав гэж Би чамд зөвлөө. ¹⁹Би хайрладаг хүмүүсээ зэмлэдэг, сахилгажуулдаг юм. Тиймээс зүтгэлтэй бай, гэмш. ²⁰Харагтун, Би үүдэн дээр зогсоод тогшиж байна. Хэрэв хэн нэгэн нь Миний дууг сонсоод хаалгаа нээвэл, Би түүний дотор орж, түүнтэй хамт, тэр Надтай хамт хооллоно. ²¹Би ялж, Эцэгийнхээ хамт Түүний сэнтийд заларсны адил Надтай хамт Миний сэнтийд залрахыг ялагчид соёрхоно. ²²Чуулгануудад Сүнс юу айлддагийг чихтэй нэгэн нь сонсогтун” гэв. (Илчлэлт 3:14-22 АБ 2004)

[] Та сүмийнхээ соёлд сэтгэл хангалуун байна уу?

[] Та нүгэлтнүүдийн наманчлалыг өөрийн сүм дотор харсан уу?

[] Та сүмээрээ бахархдаг уу?

[] Та наманчлах хэрэгтэй гэж бодож байна уу?

ЭШ ҮЗҮҮЛЭГЧ

28.9 Эш үзүүлэгч нэр хүндгүй

⁵³Есүс эдгээр сургаалт зүйрлэлүүдийг ярьсныхаа дараа тэндээс явав. ⁵⁴Тэр төрөлх хотдоо ирээд, синагогт нь тэднийг сургахад тэд гайхшран -Энэ мэргэн ухаан, эдгээр гайхамшигт хүчийг энэ хүн хаанаас авсан юм бол? ⁵⁵Энэ чинь мужааны хүү биш бил үү? Эхийг нь Мариа, дүү нарыг нь Иаков, Иосеф, Симон, Иуда гэдэг биш бил үү? ⁵⁶Охин дүү нар нь бүгд бидэнтэй хамт байгаа биз дээ? Тэгвэл энэ хүн тэр бүхнийг хаанаас авав? гэцгээв. ⁵⁷Тэд Түүнд гомдов. Харин Есүс тэдэнд -Эш үзүүлэгч нь төрөлх нутаг, гэрийнхнээсээ өөр газар л хүндлэгддэг юм гэж айлдав. ⁵⁸Тэдний итгэлгүй байдлаас болж Тэр тэнд олон гайхамшиг үйлдсэнгүй. (Матай 13:53-58 АБ 2004)

[] Үнэнийг ярихад тань таны сайн танил хүмүүс дурамжхан байна гэдгийг та мэдэж байна уу ?

[] Үнэн нь ертөнцийнх биш учраас хүмүүсийн төсөөлөл үүний эсрэг үйлчилж байгааг та мэдэх үү?

28.10 Эш үзүүлэгийн тайлбар

¹²Тиймээс хэдийгээр та нар эдгээр зүйлсийг мэдэх бөгөөд эдүгээ өөрсдөд чинь байгаа үнэн дотор батажсан байлаа ч гэсэн би та нарт эдгээрийг сануулахад ямагт бэлэн байх болно. ¹³Би энэхүү асар дотор байх цагтаа та нарыг сануулгаар сэрээхээ би зөв гэж үзэж байна. ¹⁴Ингэхдээ бидний Эзэн Есүс Христийн надад тодорхой болгосончлон, би удахгүй асраа тайлахаа мэдэж байна.

¹⁵Намайг одсоны дараа та нар ямар ч үед эдгээр зүйлийг санах чадвартай байгаасай гэсэндээ би бас хичээх болно.

¹⁶Бид өөрсдийн Эзэн Есүс Христийн хүч чадал болоод Түүний ирэх тухай та нарт мэдүүлэхдээ ухаалгаар зохиогдсон үлгэр домгуудыг дагаагүй, харин бид Түүний сүр жавхланг нүдээр гэрчлэгчид байсан. ¹⁷Учир нь Түүнийг Эцэг Бурханаас хүндлэл ба алдрыг хүлээн авах үед Сүр Жавхлант Алдараас “Энэ бол Миний хайртай Хүү. Түүнд Миний таалал оршдог” гэсэн дуу гарав. ¹⁸Бид Түүнтэй хамт ариун уулан дээр байхдаа тэнгэрээс гарсан энэ дууг сонссон билээ.

¹⁹Бид илүү баттай болгогдсон эш үзүүлэгийн үгтэй. Үүр цайж, үүрийн цолмон зүрхэнд тань гийх хүртэл, харанхуй газарт гэрэлтэж буй дэнлүүг анхаарах мэт та нар түүнд анхаарал тавихдаа сайн байдаг.

²⁰Судрын нэг ч эш үзүүлэгч эш үзүүлэгчийн өөрийнх нь тайлбараар ирээгүйг юуны түрүүнд мэдэгтүн. ²¹Учир нь нэг ч эш үзүүлэгч хэзээ ч хүний хүслээр гарсангүй, харин Ариун Сүнсээр хөдөлгөгдсөн хүмүүс Бурханаас айлджээ. (2 Петр1:12-21 АБ 2004)

[] Чуулган яагаад эш үзүүлэгчид болон шавь нарын сургаал дээр сууриллагдах ёстой болохыг та мэдэх үү?

[] Эш үзүүлэгийг яагаад Сүнсээр тайлбарлах ёстойг та мэдэх үү?

28.11 ХУУРАМЧ ЭШ ҮЗҮҮЛЭГЧ

¹⁴Чиний хөөж гаргах эдгээр үндэстнүүд нь совин тайлагч, мэргэ төлөгчдийг сонсдог. Харин чиний хувьд, ЭЗЭН Бурхан чинь чамайг тэгэхийг зөвшөөрөхгүй. ¹⁵ЭЗЭН Бурхан чинь чиний төлөө та нарын дундаас, ах дүү нарын чинь дотроос

над шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж ирнэ. Та нар түүнийг сонсогтун. ¹⁶Энэ нь Хороб ууланд чуулган болсон тэр өдөр чи ЭЗЭН Бурханаасаа гуйсан бүхний чинь дагуу юм. Тэгэхэд чи ”ЭЗЭН Бурханы минь дуу хоолойг надад дахин бүү сонгооч. Энэ их галыг надад дахин бүү харуулаач. Би үхчих вий” гэж хэлсэн билээ. ¹⁷ЭЗЭН надад “Тэдний хэлсэн үг зөв байна. ¹⁸Би тэдний ах дүү нарынх нь дундаас чам шиг нэгэн эш үзүүлэгчийг гаргаж, Өөрийнхөө үгийг түүний аманд тавина. Миний түүнд тушаах бүхнийг тэр тэдэнд хэлнэ.

¹⁹Миний нэрээр түүний хэлэх Миний үгийг сонсохгүй хэн бүхэн Миний шийтгэлийг хүлээх болно. ²⁰Харин Миний хэлэгтүн гэж тушаагаагүй үгийг эш үзүүлэгч Миний нэрээр дураараа яривал, эсвэл өөр бурхдын нэрээр яривал тэр эш үзүүлэгч үхэх болно” гэсэн. ²¹Та нар дотроо “ЭЗЭНий айлдаагүй үг гэдгийг бид яаж мэдэх билээ?” гэж бодох биз ээ. ²²Хэрэв эш үзүүлэгчийн ЭЗЭНий нэрээр хэлсэн зүйл болох ч үгүй, биелэх ч үгүй байвал тэр нь ЭЗЭНий айлдсан үг биш. Тэр эш үзүүлэгч үүнийг дураараа хэлсэн байх тул чи түүнээс бүү ай. (Дэд хууль 18:14 -22 АБ 2004)

⁹Харин, хэрэв эш үзүүлэгч үг хэлэхээр ятгагдсан бол тэр эш үзүүлэгчийг ятгасан нь ЭЗЭН Би бөгөөд Би түүний эсрэг мутраа сунгаж, Өөрийн ард түмэн Израилийн дундаас түүнийг устгах болно. (Езекиел 14:9 АБ 2004)

¹⁶Учир нь энэ хүмүүсийн газарчлагчид нь тэднийг төөрүүлж, тэднээр газарчлуулсан хүмүүс нь будлин самуурдаг. (Исаиа 9:16 АБ 2004)

[] Тэд "Их Эзэний нэрээр биелэгдэг" гэж тунхаглаж байна уу?

[] Тэд өөрийн ашиг сонирхлын төлөө мөнгө эсвэл өргөл шаардсан уу ?

[] Үзмэрчүүдийн чадварыг эш үзүүлэгтэй андуурч байна уу?

[] Бүх хүмүүс тэр хүний тухай сайн ярьдаг уу?

Бурхан эш үзүүлэгчдийг сүйрэл хүртэл мэхэлж чадна гэдгийг та мэдэх үү?

28.12 Эш үзүүлэгч мөн эсэхийг тодорхойлох хяналтын хуудас

Эш үзүүллэг нь зөв замд буцаж ирэх, судраас заавар болон замыг олохын тулд бичигдсэн. Хэрэв эш үзүүллэг эсвэл сургаал нь Бурханы бичсэн үгээс биш бол бүү итгээрэй.

Дараах хяналтын хуудас нь худал эсвэл гуйвуулагдсан эсэхийг илчилж ялгаж өгнө.

Тэдний гол зорилго нь дараах зүйлд чиглэгдэж байна уу?

Мөнгө

Алдар нэр

Захиран тушаах

Хувийн ашиг сонирхлын төлөөх зүйлс

Тэд дараахь шиг байна уу? Үүнд:

Христийн хоёр дахь ирэлтийн цаг эсвэл огноог тогтоож хэлдэг.

Тансаг амьдралын хэв маягаар амьдрахыг голчлох

Тэд сургаж заадаг шигээ амьдардаггүй

Ёс суртахуунгүй эсвэл гэмшдэггүй

Биелэгдээгүй эш үзүүллэгүүдийг эш үзүүлдэг

Бурханы бичигдсэн үгээс илүүгээр эш үзүүллэгийг сурталчлах

Өөрсдийнхийг л үнэн гэж зарлах

Бардам, ихэрхэг

Шуналтай